

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/070/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баянхонгор хот

2026 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ариун төгс оршихуй аудит"
ХХК-ийн захирал: Г.Баялаг
Утас: 9902365 Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ . Error! Bookmark not defined.	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БААЦАГААН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Д.БОЛОРМАА
ТАНАА

2026.02.25 № 2/137

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөх оны авлагын үлдэгдэл 80,939,2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн авч барагдуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>158,191,435.32</u>	<u>203,707,135.33</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,580,335.79	138,883,781.28
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,580,335.79	138,883,781.28
3121	Төгрөг	30,580,335.79	138,883,781.28
31211	Төрийн сангийн харилцах	30,580,335.79	138,883,781.28
33	АВЛАГА	80,939,189.49	1,541,915.20
33300	Татаас, санхүүжилтийн авлага	80,939,189.49	1,541,915.20
35	БАРАА МАТЕРИАЛ	46,671,910.04	63,281,438.85
351	Түүхий эд материал	20,820,000.34	5,865,397.15
35130	Эм боох материал	20,820,000.34	5,865,397.15
354	Хангамжийн материал	25,851,909.70	57,416,041.70
35410	Бичиг хэргийн материал	600,000.00	876,000.00
35420	Аж ахуйн материал	24,287,301.40	55,857,773.40
35460	Хүнсний материал	326,445.00	44,105.00
35470	Бусад хангамжийн материал	638,163.30	638,163.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,240,900,139.13</u>	<u>1,139,256,584.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,240,900,139.13	1,139,256,584.89
392	Биет хөрөнгө	1,232,479,397.48	1,130,929,343.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	852,235,107.12	852,235,107.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-119,143,221.58	-161,611,520.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	255,202,238.00	215,742,238.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,614,602.11	-26,222,492.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	347,583,927.74	382,060,727.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-150,810,542.88	-203,299,059.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,428,622.26	89,428,622.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,720,553.34	-30,372,701.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,560,880.25	23,210,880.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,242,457.98	-10,242,457.94
393	Биет бус хөрөнгө	8,420,741.65	8,327,241.61
39301	Програм хангамж	467,500.00	467,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-38,958.35	-132,458.39
39303	Бусад биет бус хөрөнгө	8,442,200.00	8,442,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,399,091,574.45</u>	<u>1,342,963,720.22</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>40,411,944.71</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,411,944.71	00.00
413	Өглөг	40,411,944.71	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,324,862.23	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	34,858,732.48	00.00



4136	Бусад өглөг	1,228,350.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,228,350.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,358,679,629.74	1,342,963,720.22
51	Засгийн газрын хувь оролцоо	1,358,679,629.74	1,342,963,720.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	457,476,951.22	457,476,951.22
51101	Өмч: - төрийн	457,476,951.22	457,476,951.22
512	Хуримтлагдсан үр дүн	751,891,015.49	736,175,105.97
51210	Өмнөх үеийн үр дүн	751,891,015.49	751,891,015.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-15,715,909.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	149,311,663.03	149,311,663.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,399,091,574.45	1,342,963,720.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,108,062,745.44	1,256,138,423.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142,671,300.18	2,622,119.00
120	Нийтлэг татварын бус орлого	142,671,300.18	2,622,119.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,000,000.00	1,971,877.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	1,971,877.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	965,391,445.26	1,253,516,304.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,564,500.00	95,561,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,564,500.00	95,561,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	915,826,945.26	1,157,955,204.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	915,826,945.26	1,157,955,204.80
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,049,316,630.09	1,271,854,333.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,049,316,630.09	1,271,854,333.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,049,261,585.80	1,241,828,526.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	667,748,946.45	788,819,263.41
210101	Үндсэн цалин	381,487,457.41	452,484,786.12
210102	Нэмэгдэл	225,744,638.50	231,425,407.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,806,000.00	30,855,085.89
210104	Урамшуулал	46,710,850.54	74,053,983.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,807,040.11	99,545,234.27
210201	Тэтгэврийн даатгал	58,678,665.33	67,797,040.51
210202	Тэтгэмжийн даатгал	6,675,833.54	7,823,625.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,210,046.17	4,176,028.97
210204	Ажилгүйдлийн даатгал	1,940,879.59	3,907,852.69
210205	Эрүүл мэндийн даатгал	13,301,615.48	15,840,686.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,009,455.71	57,750,625.94



Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	5,373,855.71	6,134,625.94
210302	Түлш, халаалт	41,200,600.00	50,866,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,435,000.00	750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,636,741.50	47,446,888.50
210401	Бичиг хэрэг	4,196,900.00	8,709,840.00
210402	Тээвэр, шатахуун	26,172,841.50	26,726,148.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,197,900.00	1,606,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,282,500.00	5,904,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,776,200.00	2,165,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	10,400.00	2,334,500.00
2105	Нормативт зардал	126,803,938.95	92,332,612.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,441,828.95	76,271,112.90
210502	Хоол, хүнс	17,311,110.00	16,061,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,051,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,438,656.00	16,115,300.00
210602	Тавилга	4,200,000.00	00.00
210604	Урсгал засвар	17,238,656.00	16,115,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,135,600.00	3,978,000.00
210702	Дотоод албан томилолт	4,135,600.00	3,978,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	257,400.00	3,133,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,400.00	283,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,423,807.08	132,707,601.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,458,383.45	5,272,580.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,965,423.63	127,435,021.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,044.29	30,025,807.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	13,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	13,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	55,044.29	3,490,474.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,044.29	3,490,474.06
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	13,335,333.20
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	13,335,333.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	58,746,115.35	-15,715,909.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	58,746,115.35	-15,715,909.52



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	930,414,359.77	1,334,885,456.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,000,000.00	1,971,877.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,000,000.00	1,971,877.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,000,000.00	1,971,877.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	1,971,877.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	900,414,359.77	1,332,913,579.09
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,564,500.00	95,561,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,564,500.00	95,561,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	850,849,859.77	1,237,352,479.09
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	850,849,859.77	1,237,352,479.09
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	905,544,196.54	1,187,856,210.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	905,544,196.54	1,187,856,210.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	905,489,152.25	1,171,165,736.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	663,424,084.22	792,814,039.75
210101	Үндсэн цалин	376,889,714.27	453,813,648.35
210102	Нэмэгдэл	226,017,519.41	231,363,640.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,806,000.00	33,055,000.00
210104	Урамшуулал	46,710,850.54	74,581,751.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,807,040.11	101,604,220.16
210201	Тэтгэврийн даатгал	58,678,665.33	68,475,683.84
210202	Тэтгэмжийн даатгал	6,675,833.54	7,823,625.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,210,046.17	4,506,114.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,940,879.59	3,229,209.36
210205	Эрүүл мэндийн даатгал	13,301,615.48	17,569,586.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,009,455.71	57,750,625.94
210301	Гэрэл, цахилгаан	4,493,855.71	6,134,625.94
210302	Түлш, халаалт	42,080,600.00	50,866,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,435,000.00	750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,904,221.00	48,262,969.00
210401	Бичиг хэрэг	3,951,500.00	6,227,200.00
210402	Тээвэр, шатахуун	18,727,521.00	32,442,569.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,606,800.00
210404	Ном, хэвлэл	00.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,418,400.00	3,426,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	4,500,000.00
2105	Нормативт зардал	68,372,726.21	112,889,861.69



Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,284,426.21	88,566,351.69
210502	Хоол, хүнс	15,933,300.00	16,524,510.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,155,000.00	7,799,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	44,502,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	10,182,900.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	34,320,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,135,600.00	3,978,000.00
210702	Дотоод албан томилолт	4,135,600.00	3,978,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	257,400.00	3,133,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,400.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,078,625.00	6,230,120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,078,625.00	6,230,120.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,044.29	16,690,474.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	13,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	13,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	55,044.29	3,490,474.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,044.29	3,490,474.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,870,163.23	147,029,245.49
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	38,725,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	38,725,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	38,725,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	38,725,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-38,725,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	24,870,163.23	108,303,445.49
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,710,172.56	30,580,335.79
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,580,335.79	138,883,781.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	-143,693,691.30	529,687,710.30
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	457,476,951.22	215,904,450.38	-143,693,691.30	529,687,710.30
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,831,802.56	-5,831,802.56
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,476,951.22	149,311,663.03	751,891,015.49	1,358,679,629.74

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	457,476,951.22	149,311,663.03	751,891,015.49	1,358,679,629.74
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,715,909.52	-15,715,909.52
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	457,476,951.22	149,311,663.03	736,175,105.97	1,342,963,720.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,336,962,200.00	1,131,220,515.61	205,741,684.39	84.1%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,336,962,200.00	1,131,220,515.61	205,741,684.39	84.1%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,336,962,200.00	1,131,220,515.61	205,741,684.39	84.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	943,372,300.00	793,013,644.76	150,358,655.24	84.1%
210101	Үндсэн цалин	621,105,500.00	454,013,253.36	167,092,246.64	73.1%
210102	Нэмэгдэл	126,000,100.00	231,363,640.05	105,363,540.05	183.6%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,222,100.00	33,055,000.00		
210104	Урамшуулал	134,044,600.00	74,581,751.35	59,462,848.65	55.6%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,854,600.00	101,604,220.16	17,250,379.84	85.5%
210201	Тэтгэврийн даатгал	80,009,800.00	68,475,683.84	11,534,116.16	85.6%
210202	Тэтгэмжийн даатгал	9,711,200.00	7,823,625.44	1,887,574.56	80.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,855,600.00	4,506,114.86	349,485.14	92.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	4,855,600.00	3,229,209.36	1,626,390.64	66.5%
210205	Эрүүл мэндийн даатгал	19,422,400.00	17,569,586.66	1,852,813.34	90.5%
2104	Хангамж, бараа материалын зардал	79,261,800.00	48,262,969.00	30,998,831.00	60.9%
210401	Бичиг хэрэг	6,227,200.00	6,227,200.00	0.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	62,851,100.00	32,442,569.00	30,408,531.00	51.6%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,737,100.00	1,606,800.00	130,300.00	92.5%
210404	Ном, хэвлэл	500,000.00	60,000.00	440,000.00	12.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,446,400.00	3,426,400.00	20,000.00	99.4%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0%
2105	Нормативт зардал	172,282,800.00	161,798,561.69	10,484,238.31	93.9%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,972,300.00	88,566,351.69	3,405,948.31	96.3%
210502	Хоол, хүнс	18,371,400.00	16,524,510.00	1,846,890.00	89.9%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,000,000.00	7,799,000.00	201,000.00	97.5%



Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	51,939,100.00	46,908,700.00	5,030,400.00	90.3%
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0%
2107	Томилолт, зочны зардал	6,500,000.00	3,978,000.00	2,522,000.00	61.2%
210702	Дотоод албан томилолт	6,500,000.00	3,978,000.00	2,522,000.00	61.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,171,400.00	3,133,000.00	38,400.00	98.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	850,000.00	0.00	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00	0.00	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,400.00	00.00	38,400.00	0.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	0.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,579,900.00	6,230,120.00	349,780.00	94.7%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,579,900.00	6,230,120.00	349,780.00	94.7%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,000,000.00	13,200,000.00	1,800,000.00	88.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,000,000.00	13,200,000.00	1,800,000.00	88.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,000,000.00	13,200,000.00	1,800,000.00	88.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,336,962,200.00	1,239,324,356.09	97,637,843.91	92.7%
1320	Нийгмийн даатгалын сангаас	1,304,690,200.00	1,237,352,479.09	67,337,720.91	94.8%
132001	Эрүүл мэндийн даатгалын сангаас	1,304,690,200.00	1,237,352,479.09	67,337,720.91	94.8%
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,691,700.00	1,971,877.00		
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	30,580,300.00			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		30580335.79		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		138883781.3		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баацагаан сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар хүртээмжтэй үзүүлэх чиг үүрэгтэй Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баацагаан сумын Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Мэдээллийн ит тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;
- Биеийн тамир спортын тухай хууль;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,127.9 мянган төгрөгөөр буюу 4.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30,580.3	138,883.8	108,303.4
Авлага	80,939.2	1,541.9	-79,397.3
Бараа материал	46,671.9	63,281.4	16,609.5
Үндсэн хөрөнгө	1,571,920.5	1,571,587.3	-333.2
Хуримтлагдсан элэгдэл	-331,020.3	-432,330.7	-101,310.4
Нийт хөрөнгө	1,399,091.6	1,342,963.7	-56,127.9
Өр төлбөр	40,411.9	0.0	-40,411.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,358,679.6	1,342,963.7	-15,715.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,399,091.6	1,342,963.7	-56,127.9

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө оны эхэнд 30,580.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, оны эцэст 138,883.8 мянган төгрөг болж өмнөх оноос 108,303.4 мянган төгрөгөөр буурсан;
- Авлагын дансны үлдэгдэл 80,939.2 мянган төгрөг болж, 79,397.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсантай холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 63,281.4 мянган төгрөг болж, 16,609.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант төсвийн хөрөнгөөр 175,347.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 249.2 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан. Үүнээс 158,843.8 төгрөгийн бараа материал зарцуулж, 143.4 мянган төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотой байна.;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,571,587.3 мянган төгрөг болж, 333.2 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө 39,126.8 мянган төгрөгөөр нэмэгдэн, Аймгийн ИТХ-ын 2025 оны 03 сарын 11-ний 5/06 дугаар тогтоолоор аймгийн Цагдаагийн газарт 39,460. Мянган төгрөгийн 49-48БНА улсын дугаартай фургон авто машиныг балансаас баланст шилжүүлсэн.
- Өглөг дансны оны эхний үлдэгдэл 40,411.9 мянган төгрөгийг төлж барагдуулсан байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,342,963.7 мянган төгрөг болж, 56,127.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,385,057.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 57,354.3 мянган төгрөгөөр тооцон, төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалаас 1,304,690.2 мянган төгрөгөөр, урд оны үлдэгдлийг 30,580.3 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 1,691.7 мянган төгрөг нийт 1,336,962.2 мянган төгрөгийн санхүүжих эх үүсвэрийг баталжээ.

Орон нутгийн төсвийн санхүүжилтийг 95,561.1 мянган төгрөгөөр баталжээ.

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг санхүүжүүлэх зардлын эх үүсвэрийн Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,304,690.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 95,561.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,691.7 мянган төгрөгийн орлого тус тус бүрдүүлж урьд оны үлдэгдлээс 30,580.3 мянган төгрөг нийт 1,336,962.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,237,352.5 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 1,971.9 мянган төгрөгийн, нийт 1,239,324.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 793,013.6 мянган төгрөгийг, хангамж, бараа материалын зардалд 48,262.9 мянган төгрөгийг, нормативт зардалд 161,798.6 мянган төгрөг, томилолтын зардалд 3,978.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 3,133.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 6,230.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 13,200.0 мянган төгрөг, нийт 1,131,220.5 мянган төгрөгийг зарцуулсан.

Орон нутгийн төсвөөс 95,561.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж байр ашиглалттай холбоотой зардалд 57,750.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 34,320.0 мянган төгрөг, нийт 92,070.6 мянган төгрөгийг зарцуулж, 3,490.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 1,223,291.1 мянган төгрөг буюу 84.1 хувьтай байгаа нь нэг иргэнд ногдох нормативаар тооцсон зардлыг 134,773.8 мянган төгрөгөөр, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний зардлыг 67,003.2 мянган төгрөгөөр, дээд шатны төсвөөс хуваарилсан зардлыг 12,064.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,490.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,440,583.5	1,223,291.1	217,292.4	84.9%
80302	Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	970,397.9	835,664.1	134,733.8	86.1%
81603	үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	261,993.3	194,990.1	67,003.2	74.4%
83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	112,631.1	100,566.3	12,064.8	89.3%
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	95,561.2	92,070.6	3,490.6	96.3%

Эх сурвалж: 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Баацагаан сумын Эрүүл мэндийн төв, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ариун төгс оршихуй аудит” ХХК-ийн аудитор Д.Сүхбаатар, Ч.Сэлэнгэ нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер С.Эрдэнэчимэг, захирал Г.Баялаг, хоёр дахь хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Г.Алтантуяа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Амартүвшин нар зурж ажиллажээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2025 оны анхны батлагдсан төсөв 1,368,493.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 20,527.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулах 171 мэдээлэл оруулахаас 166 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай холбогдох шалгууртай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар

Худалдан авах ажиллагаа явуулаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баацагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудитыг хийж, мөнгөн хөрөнгө, бараа материал, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн. Завсрын аудитаар зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.